



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 111

Ховд

Газар эзэмших зөвшөөрөл олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 9/05 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмшүүлэх төсөл сонгон шалгаруулалтанд оролцож ялагч болсон аж ахуй нэгжид доорх газрыг тус тус эзэмшүүлсүгэй.

1.1. Баатархайрхан баг Шинэ суурьшлын бүсэд байрлах 1 га газрыг “Гулзатын шил” ХХК /2384329/-д хаус хорооллын зориулалтаар 1 жилийн хугацаагаар,

1.2. Баатархайрхан баг Шинэ суурьшлын бүсэд байрлах 1 га газрыг “Баясгалант арвай” ХХК /4067169/-д хаус хорооллын зориулалтаар 1 жилийн хугацаагаар,

1.3. Баатархайрхан баг Шинэ суурьшлын бүсэд байрлах 1 га газрыг “Рашаант дарцагт” ХХК /5815428/-д хаус хорооллын зориулалтаар 1 жилийн хугацаагаар,

1.4. Баатархайрхан баг Шинэ суурьшлын бүсэд байрлах 1 га газрыг “Номин тунамал” ХХК /4082168/-д хаус хорооллын зориулалтаар 1 жилийн хугацаагаар,

1.5. Баатархайрхан баг Шинэ суурьшлын бүсэд байрлах 1 га газрыг “Алтанбэрс интернэшнл” ХХК /5650674/-д хаус хорооллын зориулалтаар 1 жилийн хугацаагаар,

1.6.Баатархайрхан баг Шинэ суурьшлын бүсэд байрлах 1 га газрыг “Чанартай бетон” ХХК /6361439/-д хаус хорооллын зориулалтаар 1 жилийн хугацаагаар,

2.Газар эзэмших эрх нь баталгаажсан аж ахуйн нэгжтэй газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

3.Ховд хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө болон шинэ суурьшлын бүс дэх амины орон сууцны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ